



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/205

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны хуралдааны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 09 дүгээр дүгнэлтийн дагуу ӨВАХААГ/20240102007/01/01 урилгын дугаартай Зарим сумдад автомашин, төрийн байгууллагуудад дуудлагаар үйлчлэх автомашин тендерийн 2 дугаар багц Прокурорын газарт автомашин худалдаж авах тендерийг 33,000,000 (гучин гурван сая) төгрөгөөр Отаку ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээнд заасан хуваарь гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0546

D:My Doc. Zahiramj. Zasag darga